



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№184 /394/

2022.10.13

Цаг үе, үйл явдал

Г.САЙХАНБАЯР: МӨЧРӨӨР ҮРСЭЛГЭЭ БЭЛТГЭХЭЭС АЛЬ БОЛОХ ТАТГАЛЗАЖ, ҮРЭЭР ҮРСЭЛГЭЭ ХИЙХЭЭР ЗОРЬЖ БАЙНА



санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар манлайлан оролцож долоон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 2030 он гэхэд 27 сая ширхэг мод тарихаа зарласан. Энэхүү төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мод үржүүлгийн есөн газар байгуулахаас энэ онд Зэвсэгт хүчний 017, 120, 186, 310, 336 дугаар ангид нийт 34 га талбайд мод үржүүлгийн таван газрыг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлээ. Цаашид Зэвсэгт хүчний 011, 311, 325, 327 дугаар ангиудад мод үржүүлгийн дөрвөн газрыг 2023 онд байгуулж дуусахаар төлөвлөн ажиллаж байна. Мод үржүүлгийн газраас жилд 6,2 сая орчим тарьц, суулгац бэлтгэгдэж гарна. Үүнийг нь төлөвлөсөн төсөл арга хэмжээнд нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн байр, орон сууц, хашаа байшин, амьдарч буй орчиндоо мод тарих хүсэл сонирхолтой алба хаагчдадаа дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ гэж харж байна.

зэрэг төрлийн моддыг үржүүлэх талбайг шинээр байгууллаа. Цаашдаа 2030 он хүртэл жишиг ногоон байгууламжтай анги болохоор төлөвлөн ажиллаж байна” гэсэн юм. Мөн Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн штабын дарга дэд хурандаа Ц.Гантулга “Бид хаврын мод тариалалтаар 4600 ширхэг мод бутыг тарьж ургуулсан. Үүнээс 200 гаруй нарс, гацуур, хуш зэрэг шилмүүст мод багтсан. Намрын мод тариалалтаар 500 гаруй ширхэг мод бутыг тариалаа. Үндсэндээ энэ жил анги хамт олон маань 5 мянга гаруй мод бутыг ангийнхаа ногоон хотхоны хөгжилд зориулж тарьсан байна. Мөн 11 мянган км2 талбайд зүлэгжүүлэлт, хайс, гэрэлтүүлгийн ажил хийсэн. Түүнчлэн 400 м2 газарт цэцэгт мандал, усан оргилуур, явган хүний зам тавих ажлыг хийлээ” гэв.

Түүнчлэн Батлан хамгаалах салбарын алба хаагчдадаа агро-экологийн мэдлэг олгох сургалтыг гурван үе, шаттайгаар зохион байгуулжээ. Үүний үр дүнд ойжуулагч, экологич мэргэжилтэй алба хаагчдыг бэлтгэж, анги, байгууллагуудыг агро экологийн мэргэжлийн 100 гаруй боловсон хүчнээр хангасан байна. Цаашдаа хугацаат цэргийн алба хаагчдыг мэргэжил олгох сургалтад түлхүү анхаарч, байгаль эх дэлхийдээ хайртай нэгэн болгох үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхээр ажиллаж байгаагаа тодотгосон юм.

АХМАД М.МӨНХЗОРИГ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар манлайлан оролцож, хэд хэдэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний нэг нь алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх зорилго бүхий “Эко-ногоон хотхон” төсөл юм. Улмаар Зэвсэгт хүчний 014, 015, 336, 353 дугаар ангиудад “Эко-ногоон хотхон” төслийг энэ онд хэрэгжүүлж, 13 мянган мод, бут тарьж, зүлэгжүүлэхийн зэрэгцээ усалгааны систем, зам, талбай, цахилгаан хангамж,

гэрэлтүүлэг, хашаа, хайс байгуулах зэрэг ажлыг шинээр хийж, засварлан тохижуулжээ.

Тус ажлын хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлага, алба хаагчид нэгдэн Зэвсэгт хүчний 014, 353 дугаар ангийн байрлалд мод тарьж, ногоон хөгжилд өөрсдийн хувь нэмрийг орууллаа. Тэд нийт 400 гаруй бургас, улиас, гацуур, нарсны суулгацыг суулгав.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлэхдээ, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн

Бид цаашдаа тарьц, суулгацыг бэлтгэхдээ мөчрөөр үрсэлгээ бэлтгэхээс аль болох татгалзаж, үрээр үрсэлгээ хийхээр зорьж байгаа тухайгаа онцолсон юм.

Энэ үеэр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Аюурзана “Бид ангиа эко ногоон хотхонтой болгохын тулд хэд хэдэн ажил санаачлан хэрэгжүүлж байна. Тодруулбал, энэ жил 700 гаруй мод бутыг ангийн хашаандаа суулгалаа.

Мөн нарс, бургас, улиас

“ДӨЛ”-ИЙН ШИЛДГҮҮДЭД ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

Өчигдөр Нийслэлийн ЗДТГ-аас Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл” тэмцээнд амжилттай оролцож байр эзэлсэн сурагч, багш, дасгалжуулагчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, шагнал гардуулах ёслолын ажиллагаа боллоо.

Ёслолын ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар ногоон хөгжил, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч дарга З.Төмөртөмөө, Нийслэлийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Баатархүү, Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Нийслэлийн боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Амартүвшин, “Дөл” тэмцээнд амжилттай оролцож байр эзэлсэн нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагч, дасгалжуулагч нар оролцсон юм. Энэ үеэр Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа



Г.Ялалт “Энэхүү тэмцээнийг өсвөр үеийнхэнд цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгох, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлж, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх зорилготойгоор жил бүр зохион байгуулдаг уламжлалтай.

Энэ жилийн тэмцээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж 21 аймаг,

нийслэлийн 9 дүүргийн сурагч, багш, дасгалжуулагчид, хурд хүч, авхаалж самбаа, ур ухаанаа уралдууллаа. Тэдгээрээс шалгарч тэргүүлж чадсан та бүхний цаашдын хичээл, сурлага, ажил амьдралд сайн сайхныг хүсэн ерөөе. Энэ эрчээ алдалгүй амжилт өөд улам хурдтай тэмүүлээрэй” гэлээ.

Тэгвэл, Сонгинохайрхан дүүргийн ЕБ-ын 124 дүгээр сургуулийн “Цасны барс” багийн

гишүүн сурагч Э.Ууганзаяа “Бид сар гаруйн хугацаанд маш шахуу, эрчимтэй бэлтгэлийг хийсэн. Миний хувьд цэргийн хүн болох сонирхолтой, хүсэж мөрөөддөг байсан учраас бэлтгэл хийж, тэмцээнд оролцоход тохиолдсон саад бэрхшээлүүд тийм ч хэцүү байгаагүй. Багадаа чулуу сайн шиддэг байсан учраас хамгийн сайн гүйцэтгэсэн дасгал гэвэл гранат шидэх.

Тэмцээний үеэр бэлтгэл дээрх шигээ сайн байж чадаагүй ч найзууд маань чи чадна, энд ирсэн зорилго, аав ээжийгээ бод гэж хэлсэн үг нь маш том түлхэц болсон. Бид нэгдмэл нэгэн цул болон багаар ажиллаж нэгнийгээ нөхөж, тусалж дэмжиж чадсан учраас түрүүлсэн гэж боддог. Хамгийн сайхан мөчийг нэрлэ гэвэл улсын аварга болж медалийн тавцанд зогсох тэр мэдрэмжийг юугаар ч сольшгүй. Өөрөө болон баг хамт олноороо бахархаж, өдийг хүртэл аз жаргалтайгаар дуслуулсан хөлс, хүч түүнийхээ үр шимийг хүртсэн тэрхүү мөч л хамгийн сайхан байсан” гэсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	🌧️ -4


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.430.00	3.445.0
EUR 🇪🇺	3.335.0	3.370.0
CNY 🇨🇳	479	482
RUB 🇷🇺	51.60	52.80
JPY 🇯🇵	23.90	24.40
KRW 🇰🇷	2.40	2.50

ЗУРХАЙ



2022.10.13 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 19

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.08-18.09
Барилдлага:
Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 627,677,595

Эдгэрсэн

Нийт: 607,183,872

Нас барсан

Нийт: 6,563,773

Цаг үе, үйл явдал

“ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ӨДӨРЛӨГ”
ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи хоорондын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Шинжлэх ухааны академийн харьяа зарим хүрээлэнтэй хамтран “Туршлага солилцох өдөрлөг”-ийг энэ сарын 6-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийг нээж ШУА-ийн харьяа Философийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), профессор Б.Пүрэвсүрэн, БХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Д.Содномцог нар үг хэлэв. Тус өдөрлөгийн хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб,

Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Цэргийн төв эмнэлгийн 60 гаруй эрдэмтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтнууд оролцож, ШУА-ийн харьяа Философийн хүрээлэн, Газар зүй, гео-экологийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, Одон орон, геофизикийн хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцсон юм. Эрдэмтдийг Одон орон, геофизикийн хүрээлэнгийн “Астро парк”-аар зочлох үеэр тайлбарлагч: “Анхны сансрын нисгэгчийг 1000 гаруй хүнээс

шалгаруулан авахад сүүлийн зургаан хүний нэг нь БХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D.), профессор Ш.Паламдорж гуай байсан” хэмээн тодотгосон нь онцлог мэдээлэл байлаа. Батлан хамгаалах салбарын судлаачид шинжлэх ухаанч, асуудлын мөн чанарт хандсан, цаашид хамтран ажиллах чиглэлээр олон чухал асуултын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн нь өдөрлөгийн үйл ажиллагааг улам сонирхолтой болгосон бөгөөд оролцогчид сэтгэл хангалуун буйгаа илэрхийлж байв.

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАЛЫНХАН МОД
ТАРИВ



Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхэн Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд үүрэгтэйгээр байгаа билээ. Зэвсэгт хүчнийхэн 2030 он гэхэд 27 сая мод тарьж, ургуулан ногоон орчныг бий болгох зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд Улаанбаатар хот, хангайн болон говийн бүсэд байрлах Зэвсэгт хүчний 9 ангийн байршилд долоон мод үржүүлгийн газар, хоёр мод үржүүлэг-Агро экологийн сургалтын төвийг байгуулаад байгаа юм. Энэ зорилтын хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын бүрэлдэхүүн 10 дугаар сарын 12-ны өдөр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн “Эко ногоон хотхон”-ы үйл ажиллагаатай танилцаж, тус ангийн байрлалд 250 гаруй мод тарьсан бол 10 дугаар сарын 13-ны энэ өдөр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын хамт олон байгууллагынхаа орчин тойрны ногоон байгууламжийг нь нэмэгдүүлэх зорилгоор 200 гаруй мод тарьж, услах, ойр орчныг нь тохижуулах ажлыг гүйцэтгэв. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас 2022-2023 оны сургуулийн жилд “Ногоон хөгжил-эко хотхон” төслийг харьяа нэгтгэл, ангиуддаа хэрэгжүүлж, алба хаагчдынхаа ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэхийг уриалаад байгаа юм. **АХМАД Д.БОЛОР**

ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ 90 ГАРУЙ
ХУВЬТАЙ ЯВАГДАЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалын дагуу Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, харьяа нэгтгэл, ангиуд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 90 гаруй хувьтай явагдаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд 7 чиглэлээр 1200 орчим ажил төлөвлөснөөс өдгөө төмс хүнсний ногоогоо хурааж авах, жилийн хэрэгцээний мал, мах бэлтгэх, хэрэгцээт нүүрсийг татан авах зэрэг ажлууд төлөвлөгөөний дагуу үргэлжилж байгаа юм.

АЛДАРЫН ДУГУЙЧИД ТЭРГҮҮЛЛЭЭ



Насанд хүрэгчдийн болон Мастеруудын Уулын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 01-02 хооронд Эрдэнэт хотноо 27 байгууллагын 100 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдөж, Кросс каунтри, Марафон гэсэн 2 төрлөөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд Алдар спорт хорооны ахлах дэслэгч ОУХМ Т.Төгөлдөр дасгалжуулагчтай дугуйн баг тамирчид оролцож 5 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Үүнд:
Эрэгтэйчүүдийн Кросс каунтри ангилалд:
ОУХМ Э.Билгүүнжаргал – алт
ОУХМ Б.Тэгшбаяр – мөнгө
Эмэгтэйчүүдийн Кросс каунтри ангилалд:
ОУХМ Ц.Солонго – алт
Мастеруудын Кросс каунтри ангилалд:
ОУХМ Т.Төгөлдөр – алт
Эрэгтэйчүүдийн Марафон ангилалд:
ОУХМ Б.Тэгшбаяр – мөнгө
ОУХМ Э.Билгүүнжаргал – хүрэл
Эмэгтэйчүүдийн Марафон ангилалд:
ОУХМ Ц.Солонго – алт
Мастеруудын Марафон ангилалд:
ОУХМ Т.Төгөлдөр – алт медаль тус тус хүртлээ.



СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ
№04

4. ГЭДЭС

Хүн, мал амьтны хэвлиитэй төстэй цүлхэн хэлбэрийн зурлага. Уруулын О, У, Ө, Ү эгшиг, мөн уруулын гийгүүлэгчийг бичиж тэмдэглэх үндсэн махбод болой.

Гэдсийг нурууны шугам дээрээ эгц доош буюу нуруу татаж эхлүүлээд нар зөв эргүүлж гонзгой зуван хэлбэрээр дээш эргүүлэн эхэлсэн газраа нийлүүлж нуруугаа давтан бичдэг.

45 хэмийн налуу, өндөрдүү, бөөрөнхий биш зувандуу гаргавал жинхэнэ гар бичмэлийн гэдэс махбод бүтнэ. Олон удаа бичиж байж дадна.

Дармалаар

Бичмэлээр

